| | 6.1.2 | Орон нутгаа судлах аялал зохион байгуулах | Аялал зохион байгуулсан эсэх | тоо | 1 | 4 | ОНТөсөв | 1-2-р улирал д | Хичээлийн жил болгон орон нутгаа судлах, экологийн боловсрол олгох, Монгол өв уламжлалт арга ухаанаас суралцах, ан амьтныг хайрлан хамгаалах, булгийн усны эхийг хамгаалах, нөхөн сэргээх аргачлал сэдэл өгөх түүнийг түгээн дэлгэрүүлж бусдад мэдээлэл хүргэх зорилгоор дараах аяллыг зохион байгууллаа.<br>Бүтээе хамгаалъя чуулга уулзалтад оролцсон сургуулиа төлөөлж 5 сурагч 1 багш хамрагдсан \Дундговь аймагт зохион байгуулагдсан\<br>1. Чуулга уулзалт Дундговь аймгийн хэмжээнд зохион байгуулсан Өсвөрийн байгаль хамгаалагчид чуулга уулзалт Их газрын чулуунд болсон сургуулиа төлөөлж 8 сурагч, 1 багш 1 эцэг эх хамрагдсан<br>2. Их нартын чулуунд эко үүргэвчтэй аялал<br>Туршлага судлах эко аялал тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 150 сурагч хамрагдсан | 100% |
| | 6.1.3 | Монгол хэл, түүхийн кабинетийг тохижуулах | | | | | | | С.Түмэнбаатар багш даасан ангийн эцэг эхийн 700000₮-ийн хандиваар Монгол хэлний кабинет гэрчилгээжүүлэх ажил хийгдсэн. А.Батбуян багш эцэг | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | кабинет гэрчилгээж үүлэх. | Тоо | 1 | 2 | ОНТөсөв | | эх, асран хамгаалагчидтай хамтран 850.000 төг-ийн санхүүжилтээр гэрэлтдэг “Монгол орны газрын зураг”, ханын самбаруудыг авч тохижуулав. А3 өнгөт принтер, проектор нийт 1 950 000 төг-ийн тохижилтыг хийж кабинетаа гэрчилгээжүүллээ. | |
| | 6.1.4 | Монгол бичгийн анги нийтийн уралдаан зохион байгуулах . | Монгол бичгийн олимпиадад оролцсон оролцооны хувь | Хувь | 30 | 80<br>90 | ОНТөсөв | | 6-9 ангийн 86 сурагчийн дунд Монгол бичгийн олимпиад зохион байгуулж эхний 2 байранд шалгарсан ангид “Хүмүүн бичиг” сонин захиалах эрхээр шагналаа. Үүний үр дүнд монгол бичгээр унших чадвар нэмэгдэн минутад унших үгийн тоо дунджаар 15 үгээр нэмэгдлээ. Багшийн хөгжлийн бүлгээс 2-9 ангийн нийт сурагчийн дунд “Өглөөг өөртөө” аяныг өрнүүлэн өдөр бүр 1 зүйр үгийг монгол бичгээр бичүүлэн дэвтрээр үзэсгэлэн гарган 14 хоног тутамд шалгалт авч хэвшлээ. Нийт төрийн албан хаагчдын дунд түвшин тогтоох сорил авч гараа тодорхойлон гарааны үнэлгээгээр 80 -аас дээш хувьтай үнэлэгдсэн 12, 90-ээс дээш хувьтай үнэлэгдсэн 3 нийт 15 хүнд батламж гардууллаа. Ерөнхий боловсролын сургуулийн багш ажилчдын дунд монгол бичгийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | сургалт тогтмол 14 хоног тутамд зохион байгуулагдаж сорил авч ахицыг тооцон ажиллаж байна.Төрийн албан хаагчдын дунд монгол бичгийн цэвэр бичгийн уралдаан зохиож 94 хувь нь оролцлоо. | |
| Зорилт | 6.2 | Бие дааж сурч хөгжих, амьдрах чадвартай Монгол хүүхэд төлөвшүүлэх ажил 2020 онд 50 хувь байгаар 2024 онд 80 хувь болгоно. | Зүрх сэтгэлийн боловсрол олгох сургалтад хамруулсан байх | Хувь | 50 | 80 | ОНТөсөв | Жилдээ | НАЗА академийн сургагч багш Э.Даваадоржийн сургалтад 2 удаа хамрагдаж зөв монгол хүүхэд сургалтыг сумын хамтарсан багтай хамтран зохион байгуулсан. Сургалтад 6-9-р ангийн 80 сурагч хамрагдсан. | 90% |
| Арга хэмжээ | 6.2.1 | Технологийн кабинетийг байгуулж, орчинг бүрдүүлэн амьдрах арга ухааны сургалтын хөтөлбөр, төсөл боловсруулан сургалт зохион байгуулах. | Технологийн кабинет байгуулж орчин бүрдүүлж ажиллах | хувь | 20 | 60 | Байгууллагын төсөв | Жилдээ | Технологийн кабинетын төсөл дэжигдээгүй боловч өөрийн нөөц боломцоондоо тулгуурлан групээр хичээллэх ангийг тохижуулан ажиллаж байна. тохижилт 50 хувь. | 50% |
| | 6.2.2 | Хүүхдийн оролцооны байгууллага, клубуудыг байгуулан идэвхтэй үйл | Үйл ажиллагаа нь тогтмолжсон клубын тоо. | Тоо | 5 | 6 | ОНТөсөв | | 2023-2024 оны хичээлийн жилд “Өсвөрийн сэргийлэгч”, “Өсвөрийн сурвалжлагч”, “Охидын зөвлөл”, “Эко клуб”, “Бөхтийн хүчтэн” дэвжээ, “Ногоон бэрс” гэсэн оролцооны | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагаа явуулах | | | | | | | 6-н өөрөө удирдах байгууллага байгуулан ажиллалаа. | |
| | 6.2.3 | “Бяцхан манлайлагч” арга хэмжээг зохион байгуулж өөртөө итгэлтэй, бие даах чадвартай суралцагчдын баг, хамт олныг төрүүлэн алдаршуулах | Баг хамт олны хуваарилалт, зохион байгуулсан ажлын тоо | Тоо | 0 | 5 | ОНТөсөв | 1-2-р улиралд | “Бяцхан манлайлагч” арга хэмжээний хүрээнд “Хамтдаа давъя” гар зургийн уралдааныг 1-5-р ангийн сурагчдын дунд зарлаж 30 бүтээл ирснээс шилдэг 10 бүтээл шалгаруулж, байр эзлүүлэв. Хүүхдийн уран сайхнаар сэтгэн бодох чадварыг нэмэгдүүлэн авьяас чадварыг нээн хөгжүүлж бүтээлийг сургуулийн брэнд бэлэг дурсгалын зүйл болгож эхний бүтээлийг аймгийн засаг даргад гардуулав. “Инээдэг цэцэгс” аян өрнүүлж дотуур байранд жижүүр багш 16 удаа очиж ажиллан хичээлүүдээр давтлага зөвлөгөө өгч хүмүүжлийн яриа 5 удаа хийж СНА дотуур байрын багштай хамтран тасгуудын дунд урлагийн номер үзүүлэх уралдаан зарлаж тэдний тоглолтын бичлэгийг эцэг эх асран хамгаалагч нарт дотоодын групп чатаар хүргэж ажиллалаа. “Төлөвлөж сурья” аянд 6а анги шалгарч ангийн 28 хүүхэд “Зорилготой ирээдүйн эзэд” гэсэн дэвтрийг анги удирдсан багштай хамтран авч өгөн ашиглуулж байна. 6 ажил зохион байгуулав. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 6.2.4 | Хүүхэд хөгжлийн танхимыг тохижуулж үйл ажиллагаа зохион байгуулах | Хичээлийн бус цагаар өөрийгөө хөгжүүлэх орчин нөхцөл бүрдүүлэлт, зохион байгуулсан ажилд оролцсон суралцагчийн эзлэх хувь | хувь | 30 | 40 | ОНтөсөв | | Дотуур байрын багш, ажилчдын санаачилгаар “Ардын тоглоом наадгай”, “Монгол бичиг”, “Англи хэл”, “Гитар суръя” булан байгуулж, өөрсдийн сонирхол чадвараар 10-аас дээш хүүхэд хариуцан авч хөгжүүллээ. 11 хүүхдэд гитар тоглохыг заан 2 ая тоглож сурав. 4 удаа 21 хүүхдийг хамруулан волейболын тэмцээн зохион байгуулав. Монгол бичгийн уншлага, зүйр цэцэн үг хөрвүүлэх уралдааны удирдамж гарган 2 удаа 25 хүүхэд хамруулан зохион байгуулж унших чадвар дээшлэв. 81 000 төг-өөр хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 4 төрлийн тоглоом авч тохижууллаа. ”Хүүхэд хөгжил” хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна. Дотуур байрын сурагчдыг уг үйл ажиллагаанд 100 хувь оролцууллаа. | 100% |
| | 6.2.5 | Ээлжит хичээлээр “Хүүхдийг төлөвшүүлж байгаа нь” сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдааныг жил | Илтгэлийн уралдаан зохион бйагуулсан эсэх | Тийм/үгүй | 1 | 3 | ОНТ | Жилдээ | БШУЯ Боловсролын ерөнхий газраас жил бүр изохион байгуулагддаг эрдэм шинжилгээний бага хурал,сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдаанд бүлгийн багш нар болон эрхлэгч аргазүйч нар ганцаарчлан болон багаар жил бүр тогтмол | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүр зохион байгуулах | | | | | | | амжилттай оролцсон.Нийт 4 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 24 оролцогч хамрагдсан. | |
| Зорилго: Эрүүл аюулгүй орчинд тоглож, энгийн дадал хэвшилд суралцан, сургуульд бэлтгэгдэх, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх. | | | | | | | | | | |
| Зорилт | 7.1 | Хүүхдийн суралцах, төлөвших, авьяас чадварыг хөгжүүлэхэд багш, сургууль, СӨБ-тэй хамтран сургалтын орчин бүрдүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх ивээн тэтгэх эцэг эхийн оролцоог 2020 онд 40 хувь байгааг 2024 онд 75 хувьд хүргэнэ. | Эцэг эхийн оролцооны хувь | Хувь | 40 | 75 | ОНТ хандив | Жилдээ | Анги бүлгүүд эцэг эхийн зөвлөлөө байгуулан түүнээс байгууллагын эцэг эхийн зөвлөлийг эрхлэгчийн 2021/09/25-ны А/15 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгууллаа.Эцэг эхийн зөвлөлийн төлөвлөгөө гарган ажиллаж байна.Бүлгүүдийн эцэг эхийн зөвлөлүүдийн санаачлагаар хүүхдийн сурах хөгжих орчин бүрдүүлэх зорилгоор хандивын аян өрнүүлж нийт 42 нэр төрлийн 8548000 төгрөгийн өртөг бүхий хөрөнгө, тоглоом сургалтын хэрэглэгдэхүүн авсан. | 70% |
| Арга хэмжээ | 7.1.1 | “Эцэг эхийн боловсрол” сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Сургалтын тоо, хамрагдалт | Тоо | 3 | 6 | 1.000.000 | Жилдээ | Хичээл сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулсантай холбогдуулан АУБ- нар цахим сүлжээг хэрхэн ашиглах талаарх заавар зөвлөгөөг өгч ажиллаж байна. Үүнд:Google meet, gmail,zoom, Facebook, messenger, гэх мэт програм болон цахим сүлжээнд хэрхэн ажиллах талаарх сургалтыг 3 удаагийн давтамжтай зохион байгуулж | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | нийт давхардсан тоогоор 310 эцэг эх хамрагдсан байна. Энэхүү сургалтыг зохион байгуулснаар хичээл сургалтын үйл ажиллагаа цахимд шилжсэнтэй холбогдуулан эцэг эх суралцагчидтайгаа ажиллахад илүү үр дүнтэй байна. Мөн цахим сүлжээ болон сумын “БӨХТ”-группд Хүүхэд хамгааллын тухай хууль, халдвар хамгааллын дэглэм баримтлах зөвлөмж, хүүхэд хүмүүжлийн эерэг аргуудаас, хүүхдийн эрх гэж юу вэ?, Гар утасны хортой туяаны талаарх мэдээ мэдээлэл, болон заавар зөвлөгөөг өгч ажиллалаа нийт давхардсан тоогоор 1800 орчим сурагч , эцэг эх асран хамгаалагчдад хүрсэн байна. Эцэг эх асран хамгаалагчдад Боловсролын тухай шинэчилсэн хууль, хүмүүжлийн эерэг арга сэдвүүдээр 2 удаа, эцэг эх асран хамгаалагчдын спортын бага наадам зэрэг үйл ажиллагааг нийт эцэг эхийн дунд зохион байгуулсан. Бага ангийн багш нар эцэг эхчүүдэд тухайн 7 хоног, сар, улирлаар заах хичээлийн сургалт зөвлөгөөг тогтмол өгч хэвшсэн. | |
| | 7.1.2 | Гэр бүлийн орчинд хүүхдийг бие дааж | Шилдэг эцэг эхийн арга | | | | - | Жилдээ | Цахим сургалтын үед хүүхдийнхээ сурч хөгжихөд нь дэмжлэг үзүүлж | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сурах арга барил эзэмшихэд дэмжлэг туслалцаа үзүүлдэг эцэг эхийн арга барилыг олон нийтэд сурталчилах. | барилыг сурталчилан таниулах Сурталчилга а хийсэн тоо Хамрагдсан иргэдийн тоо | Тоо | 1<br>35 | 3<br>70 | | | хамтран ажиллаж байсан гэр бүлийг “Өндөршил цэцэрлэг“ группдээ суртчиллаа.Мөн бүлгүүдийн цахим хуудсуудад эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 3 төрлийн цахим уралдааныг зарлаж нийт давхардсан тоогоор 76 эцэг эх хамрагдсан. | 100% |
| | 7.1.3 | “Эцэг эхийн манлайлал”, “Аавуудын үлгэрлэл” чуулга уулзалт, “зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | тоо | - | 2 | ОНТ | Жилдээ | ҮБ | |
| | 7.1.4 | Эцэг, эхийн спортын бага наадмыг зохион байгуулах | Зохион байгуулсан эсэх | Тийм/үгүй | - | 3 | ОНТ | жилдээ | Эцэг эхийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх идэвх оролцоог нэмэгдүүлэх, сургууль эцэг эх асран хамгаалагчдын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор спортын бага наадмыг жил бүр уламжлал болгон шилжин явах цомтойгоор зохион байгуулж эцэг эхийн оролцоо хамтын ажиллагааг нэмэгдүүлдэг. Мөн шилдэг асран хамгаалагчтай анги хамт олон , шилдэг асран хамгаалагчдыг тус тус шалгаруулж ажиллаж байна. | 70% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 7.1.5 | Шефийн харилцаа холбоог сайжруулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | тоо | - | 2 | ОНТ | Жилдээ | ҮБ | |
| | 7.1.6 | “Хүүхдийн төлөө за гэж хэлье” аян зохион байгуулах. | я ны арга ижээг тусгай дамжийн у зохион уулах он уулсан ын тоо | Тоо | 0 | 3 | ОНТөсөв | | Байгууллагын албан хаагчид болон эцэг эх асран хамгаалагчдын дунд “Хүүхдийн төлөө за гэж хэлье” аяныг удирдамжийн дагуу 3 удаа зохион байгууллаа. Аянд давхардсан тоогоор 178 хүн хамрагдлаа. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын эцэг эх, асран хамгаалагчдын дунд “Хүүхдийн төлөө за гэж хэлье” аяныг өрнүүлэн тасаг өрөө тохижуулах ажлыг санаачлан хийж 4 сая төг-ийн хөрөнгө оруулалт хийж амьдрах орчныг сайжрууллаа. Жил бүр 1-р ангийн эцэг эхчүүд санаачлан анги тохижилтын ажлыг хийж хээвшсэн. | 100% |
| Зорилго : 8.1 Бүх нийтийн боловсролын сургалтын хэрэгцээг тодорхойлж хэрэгжүүлнэ | | | | | | | | | | |
| Зорилт | 8.1.1 | Насан туршийн боловсрол олгох сургалтын орчин нөхцөл бүрдүүлэлт 2020 онд 45 хувьтай байгааг 2024 онд 70 хувь болгоно | Сургалтын орчин зайлшгүй хэрэгцээтэй сургалтын техник хэрэгсэл хэрэглэгдэ | Хувь | 45 | 55 | Улсын төсөв | | Сургалтын танхимд хэрэглэгдэхүүний тавиур шинээр нэмж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох гарын авлага 10, багшийн ном 1,2,3, сурагчийн 3 ширхэг номоор баяжууллаа. Мөн “Бүгдээрээ хуримтлуулъя” аяны хүрээнд санхүүгийн | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүүний судалгаа гарган үе шаттайгаар бүрдүүлэх | | | | | | боловсрол олгох тухай гарын авлага 40 ширхэг, амьдрах ухааны гарын авлага 50 ширхэг нэмсэн. Боловсрол нөхөн олгох хөтөлбөрийг шинэчлэн хэрэглэгдэхүүний баяжилт хийв. Шинэ зөөврийн компьютерээр хангав. | |
| Арга хэмжээ | 8.2 | Насан туршийн боловсролын танхим байгуулж сургалтын үйл ажиллагааг явуулах. | Сургалт явуулах орчин бүрдүүлж кабинетийн гэрчилгээт эй болох. | Тоо | 0 | 1 | 500 000 | | Насан туршийн боловсролын нэгжийн танхимыг өнгөт принтер, зөөврийн компьютерээр хханган хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүний баяжилт хийв. Ногоон бэрс шатрын клуб ажиллуулж байна. 75инчийн зурагттай болж цахим танхим болгохоор бэлтгэж байна. | 90% |
| Зорилт | 8.2 | Хүн амын боловсролын түвшинг судалж хэрэгцээг тодорхойлон явуулж буй сургалтад хамрагдалт 2020 онд 20 хувь хамрагдаж байгааг 2024 онд 50 хувь хамруулна. | Судалгааг авч дүгнэлт хийн сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулж сургалтыг тогтмолжуулан зохион байгуулж хамрагдалтыг зорилтот хувьд хүргэх. | Хувь | 25 | 30 | ОНТ | Жилдээ | Сумын нийт иргэдийн боловсролын түвшинг тогтоох судалгаа хийн бичиг үсэг үл мэдэгч 3-н иргэнд сургалнд суурь боловсрол эзэмшүүлсэн. Нийт иргэдийн дунд үндсэн 6 чиглэлээр 10 төрлийн сургалт зохион байгууллаа. Үүнд давхардсан тоогоор 560 иргэн хамрагдсан байна. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | 8.2.1 | Хүн амын боловсролын түвшинг нарийн судалж бодит судалгааг нарийвчлан гаргах. | Судалгааг авч дүгнэлт хийн сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулж сургалтыг тогтмолжуулан зохион байгуулж хамрагдалтыг зорилтот хувьд хүргэх. | Хувь | 25 | 30 | ОНТ | Жилдээ | Сумын нийт иргэдийн боловсролын түвшинг тогтоох судалгаа хийн бичиг үсэг үл мэдэгч 3-н иргэнд суурь боловсрол эзэмшүүлсэн. Нийт иргэдийн дунд үндсэн 6 чиглэлээр 10 төрлийн сургалт зохион байгууллаа. Үүнд давхардсан тоогоор 560 иргэн хамрагдсан байна. | 90% |
| | 8.2.2 | Мэргэжлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах уялдаа холбоог сайжруулан сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах . | Зохион байгуулсан ургалтын тоо | Тоо | 2 | 4 | ОНТ | Жилдээ | Аймгийн политехникийн коллежтэй хамтран төгсөх ангийн 35 сурагчид мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт өдөрлөгийг явуулж сурагчид 100 хувь хамрагдлаа. Мөн 8-9 ангийн сурагчдын дунд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт явуулсан нийт 45 сурагч хамрагдсан. | 100% |
| | 8.2.3 | Төрийн албан хаагчдын хэл бичгийн мэдлэгийг шалгах сорилго уралдааныг жилд | | | | | | | Монгол бичгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, сурч судлах, түгээн дэлгэрүүлэхэд иргэд, олон нийт, төрийн албан хаагчдын идэвхийг өрнүүлэх үүднээс төрийн байгууллага, хувийн хэвшлүүдийн “Хамтын | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2 удаа зохион байгуулах. | Эх хэл бичгийн танхимын болон цахим сургалтын тоо хамрагдалтын хувь | Хувь | 75 | 80 | 200 000 | | ажиллагаа-2023” аяны ажлын хүрээнд багуудын дунд “Монгол бичгээ дээдэлье” уламжлалт ажлыг Насан туршийн боловсролын нэгжээс зохион байгуулж байгаа билээ. 1 дүгээр шатанд 10 багийн гишүүдээс монгол бичгийн түвшин тогтоох гарааны шалгалт авч 93 хүн хамрагдсан. 2 дугаар шатанд монгол бичгийн цагаан толгойн үсэг, нэр, үйлийн нөхцөлийг хэрхэн зөв бичих хичээл, даалгаврыг цахимаар өгч бие даалган судлуулж шалгалт авав. Шалгалтад 80 орчим хүн хамрагдаж гарааны шалгалтаас 11,4 хувиар ахисан амжилт үзүүллээ. | |
| | 8.2.4 | 9-р ангийн суралцагчид, эцэг эхэд амьдрах ухаан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтуудыг зохион байгуулж, хамрагдалтыг 100 хувьд хүргэх | Сургалт хийсэн тоо Сургалтад хамрагдалтын хувь | Хувь | 75 | 100 | ОНТөсөв | | 9 дүгээр ангийн эцэг эхийн дунд нийт 5 удаа сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 100 хүн хамрагдсан. Хичээлээс гадуурх сургалтын 6-% хөтөлбөрийн дагуу төгсөх 9 дүгээр ангийн сурагчдыг эрүүл мэндийн төвийн эмнэлгийн эмч, ажилтны ажил мэргэжлийн онцлогтой танилцуулах ажлыг зохион байгуулав. | 90% |
| Зорилго:Хүүхэд бүрийн онцлог байдлыг харгалзан амьдрах, өрсөлдөх, бие даан бүтээлчээр сурах чадварыг хөгжүүлсэн эрүүл аюулгүй амьдрах, хөгжих орчин бүрдүүлэх. | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт | 9.1 | Дотуур байрын суралцагчдын эрүүл аюулгүй амьдрах, сурч хөгжих орчин бүрдүүлнэ. | Гадаад, дотоод орчны судалгаа хийж төсөл хөтөлбөрт хамрагдсан байх. | Тоо | 0 | 1 | ОНТөсөв, Улсын төсөв | | Дотор орчны эрсдлийн судалгаа хийж нийт 10 өрөө тасгийн гэрэл, разетка сольж, цахилгааны ил утсыг далдлан засварлав. Өрөө тасгийн ширээ сандлыг сэлбэн засварлаж хичээл хийх тухтай орчин бүрдүүллээ. БШУЯ-ны 500 сая төгрөгийн санхүүжилтээр 320 хүүхдийн сургууль, 80 хүүхдийн дотуур байрны АЦБ (ариун цэврийн байгууламж)-ийг бүрэн шинэчлэх ажил хийгдэж байна. | 100% |
| Арга хэмжээ | 9.1.1 | “Манай байр-Миний гэр” төсөл хэрэгжүүлэх | Төсөл, хөтөлбөр боловсруулах | Тоо | 0 | 1 | ОНТөсөв | | Дотуур байрны эцэг эх асран хамгаалагчдын дунд “Миний байр-Миний гэр” сарын аян зохион байгуулаж үйл ажиллагаа өрнүүлэн сурагчдын ая тухтай сэтгэл хангалуун эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа. | 100% |
| Зорилго 10. 2-5 насны хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэхэд оршино. | | | | | | | | | | |
| Зорилт | 10.1 | Сургалтыг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл оролцоог дэмжин тэгш хүртээмжтэй, чанартай зохион | Сургалт зохион байгуулсан тоо<br>Хэрэгжүүлж ажилласан байдал | Тоо<br>Хувь | - | 2<br>84 | ОНТ | жилдээ | ҮБ | ҮБ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулж, 2020 онуудад 74% байсныг 2024 онд 84% хувьд хүргэнэ. | | | | | | | |
| Арга хэмжээ | 10.1.1 | Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр боловсруулж, тоглоомын аргаар хөгжүүлэх. | Сургалт зохион байгуулсан тоо<br>Хэрэгжүүлж ажилласан байдал | Тоо<br>Хувь | - | 2<br>84 | ОНТ | жилдээ | ҮБ | ҮБ |
| | 10.1.2 | Хувилбарт сургалтын уялдаа холбоог нэмэгдүүлж, явуулын багш ажилуулах | | | | | | | Өндөршил сумын 1-р багт нутагладаг цэцэрлэгийн насны дөрвөн бүлгийн 12 хүүхдэд бүлгийн багш Н. Болортуяа, Э. Сувдаа нар 1070км –замыг ыг туулж “Явуулын багш”-ийн үйлчилгээ үзүүллээ. 2-р багт нутагладаг цэцэрлэгийн насны дөрвөн бүлгийн 7 хүүхдэд бүлгийн багш Г.Адьяасүрэн М. Энхжаргал нар 2 удаагийн тойролтоор нийт 712км –замыг туулж явуулын багш –ийн үйлчилгээг үзүүллээ Сургуулийн өмнөх | 70% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | боловсролыг олгох чадварт тулгуурлан гэр бүлийн орчинд тоглоомоор дамжуулж богино хэмжээний сургалт, үйл ажиллагааг зохион байгууллаа. Мөн эцэг эхийн хамтаар бие даан суралцах боломжийг ханган дасгал даалгавар, сургалтын богц өгч цахимаар эргэх холбоотой ажиллаж байна. Ингэснээр малчны хүүхдүүдийн сургалтын чанар нэмэгдэж нас насандаа эзэмших чадварын 60-70%-ийг эзэмшсэн гэсэн судалгаатай байна. | |
| | 10.1.3 | Эцэг эх, багш, ажилчдын хамтран ажиллах уялдаа холбоог сайжруулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br>Зарцуулсан төсөв | Тоо<br>төсөв | -<br>- | 15<br>30 сая | ОНТ, хандив тусламж | Жилдээ | Хамтын ажиллагааны хүрээнд цэцэрлэгийн нийт эцэг эх, асран хамгаалагчид иргэдийн дунд анги бүлэг өрөө тохижуулах ажлыг санаачлан зохион байгуулж нийт 28 нэр төрлийн 8954200 төг-ийн хөрөнгө оруулалт хийн хүүхдийн сурч хөгжих орчныг сайжруулж тохижуулллаа. Мөн "Бидний тохилог орчин" төслийн уралдаан зарлаж Гадна талбайн тоглоом, | 70% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Багш хөгжлийн төвийн төслүүд дэмжигдэж сумын ОНХС-ийн 61,324,160 төгрөгөөр санхүүжүүлэгдэн хийгдлээ. Дээрх аяны хүрээнд хийгдсэн ажлуудын үр дүнд хүүхдийн эрүүл аюулгүй сурч хөгжих таатай орчин бүрдсэн | |
| Зорилго -11Багш, ажилчид ажлын байрандаа тасралтгүй хөгжихийн тулд нэн шаардлагатай техник, хэрэгслийг ханган, ажлын байран дээрх сургалтыг тасралтгүй зохион байгуулна. | | | | | | | | | | |
| Зорилт | 11.1 | Орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан сургалтыг зохион байгуулах, цэцэрлэгийн багшийн онол, арга зүй сургалтад багш нараа хамруулж, сургалтын чанар 72 хувь байгааг, 85 хувьд хүргэнэ. | Сургалтын чанарын хувь | Хувь | - | 85 | ОНТ | Жилдээ | ҮБ | |
| Арга хэмжээ | 11.1.1 | “Багш хөгжлийн танхим” –ыг тохижуулж, шаардлагатай техник хэрэгслээр хангах. | Төхөөрөмжтэй болсон эсэх<br>Зарцуулсан төсөв | Тийм/үгүй | - | 1 | ОНХС хандив | Жилдээ | 2023 онд сумын ОНХС-ийн 25 сая төгрөгөөр байгууллагын багш хөгжлийн төвийг тохижуулсан. | 100% |
| | 11.1.2 | СӨБ-ын багш нарын заах арга барилыг нэмэгдүүлэхийн | Туршлага судалсан тоо | Тоо<br>Тоо | - | 2 | ОНТ | Жилдээ | Цэцэрлэг 3 удаагийн туршлага судлах ажилд давхардсан тоогоор 30 албан хаагч, төлөвлөгөөт 11 удаагийн сургалтад давхардсан | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тулд бусад хот, аймгийн цэцэрлэгээр жилд 1-2 удаа туршлага судлуулах | Сургалтад хамрагдсан тоо | | | | | | тоогоор 35 албан хаагч,ажлын байран дах 15 удаагийн сургалтад 125 албан хаагч хамрагдлаа | |
| | 11.1.3 | СӨБ-ын багш нарын хөгжмийн боловсролыг 45% -иар нэмэгдүүлэх | Хөгжмийн боловсролын нэмэгдэлтийн хувь | Хувь | - | 45 | ОНТ | Жилдээ | Даралтад хөгжмийн 14 хоногийн сургалтад 13 СӨБ-ийн албан хаагч хамрагдсан. | |
| Зорилт | 11.2 | Шинжлэх ухааны салбар болон гадаадад нарийн мэргэжлээр суралцаж буй оюутнууд, судлаачидтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ. | Арга хэмжээ зохион байгуулсан тоо | Тоо | - | 2 | ОНТ | Жилдээ | ҮБ | |
| Арга хэмжээ | 11.2.1 | Гадаадад сурч буй оюутан судлаачдын судалгааг гаргана | Судалгааг гаргасан эсэх | Тийм/үгүй | - | - | ОНТ | Жилдээ | Гадаад суралцаж буй 6 оюутан залуучууд байна. /Б.Баасанхүү У.Цэрэннадмид,С.Навчаа, Ж.Дөлгөөн, Н.Энхзаяа, | 70% |
| | 11.2.2 | Орон нутгийн хөгжил, хүний хөгжилд тэдний мэдлэг, туршлагад суурилсан инновацийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. | Инновацийг нэвтрүүлсэн эсэх | Тийм/үгүй | - | - | ОНТ | Жилдээ | ҮБ | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 11.2.3 | Уулзалт, ярилцлага зохион байгуулж, идэвх оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллана. | Уулзалт зохион байгуулсан эсэх | Тийм/үгүй | - | - | ОНТ | Жилдээ | ҮБ | |
| **Өв, соёлоо дээдлэгч - Өндөршилчүүд** | | | | | | | | | | |
| Зорилго: Хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын боловсролыг дээшлүүлэх, соёлын олон талт үйл ажиллагааг чанартай зохион явуулахад оршино. | | | | | | | | | | |
| Зорилт | 12.1 | 2020 онд соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдсан иргэд 2830 байсныг 2024 онд 10.000-аар нэмэгдүүлнэ | Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо | тоо | 10330 | 12830 | 125. 0 | Жилдээ. | урлаг соёлын үйлчилгээнд хамрагдсадын тоо 2021 -2024 оны стастистик тоон мэдээгээр 33,513 хүрч 20 683-н үзэгчээр нэмэгдэж 261,2 хувьд хүрсэн байна. | 100% |
| Арга хэмжээ | 12.1.1 | Цахим соёлын үйлчилгээ зохион байгуулах | Цахим соёл үйлчилгээний тоо | тоо | 5 | 30 | 300. 000 ОНТ | Жилдээ. | цахим соёлын үйлчилгээгээр Цахим үзэсгэлэн-22, мэдээлэл-189,Цахимд 159 ном бүтээл тавих, соёлын үйл ажиллагаа гээд 5 төрлөөр 131 үйл ажиллагаа зохион байгуулж, төлөвлөсөн ажлаас 31 ажил нэмэгдсэн байна. Цахим үйл ажиллагаанд 20637 хүн хандалттай байна. | 100% |
| | 12.1.2 | Үндэсний урлагийг орчин үеийн хэлбэр, дэг жаягт оруулан 2-3 уран бүтээл туурвиж, иргэд хүүхэд | Үндэсний урлагийг орчин үеийн хэлбэр, дэг жаягт оруулан ура | тоо | 3 | 5 | 50 000 | Жилдээ. | Тал нутгийн аялгуу, Бүсгүйн ертөнц, Алтан хэлхээ 3 үеийн уранбүтээл, ,Эрхэмсэг аялгуу - 2023, Хийморлог аялгуу, ӨМӨЗО-ны Ордос хотын Чингисний онгоны шүтээн Эзэн тахилын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | залуучууд, алслагдсан иргэдэд үйлчлэ | н бүтээл туурвих | | | | | туурь, Хилийн цэргийн дуу бүжгийн чуулгатай хамтран Өндөршил нутгийн дуулал, сумын 100 жилийн баяр наадмын нээлтийн үйл ажиллагааг нутгийн бахархал өв соёлоо дээдлэж үзэгч олны хүртээл болгон ажиллаа.Авьяастануудынхаа оролцоо дэмжлэг туслалцаатай нийт 13 уран бүтээл туурвиж, 345 уран бүтээлч, авьяастанууд хамрагдан оролцсон байна. | |
| | 12.1.3 | Д.Нацагдоржийн зохиол “Учиртай гурван толгой”- дуурийн хэсгийн тоглолтыг сэргээн тоглож, дүрсжүүлэх. | Сэргээн тоглож дүрсжүүлсэн эсэх | Тийм/үгүй | гүйцэтгэлээр | - | ОНТ | Жилдээ | Ардын авьяастан нартайгаа хамтран уг дуурийг сэргээн 2024 оны 11 сард тоглох, иргэдийн дунд Гол дүр Юндэн Нансалмаа, Балган нарын дүрийг хэн сайн бүтээх вэ уралдаан зохион байгуулахаар төлөвлөж байна. | 30 % |
| | 12.1.4 | “Соёлын цаг“ 14 - 21 хоногийн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах | нөлөөллийн аян өрнүүлэх | тоо | 1 | 2 | 150 0 | Жилдээ | “ХАРИУЦЛАГАТАЙ ДУНДГОВЬ-2021”аян, Соёлын сэргэлт-2023 аян,Соёлын цаг-21 нөлөөллийн аян 14-21 хоногийн аяныг 6 удаа зохион байгуулж Номтой нөхөрлөе,Баярлалаа хайртай шүү эрэг хандалгийг түгээх дуу шүлгийн уралдаан, Номын өргөөний ид шид уулзалт, Аймгийн урлагийн бага наадам, ТАХ урлагийн үзлэг, Архигүй орчин -Бидний сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг зарлан, ”Алтан хэлхээ гурван үеийн Монгол улсын | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хүүхэлдэйн театрын шинэ уран бүтээл О.Сундуйн зохиол “Хүүхэлдэйн чинээ ээж” хүүхэлдэйн жүжгийг тоглолт гээд нийгэм хариуцлагынхаа хүрээнд 110 үйл ажиллагаа зохион байгуулж, 3155 үзэгчийг хамруулж төлөвлөгөөт зорилтоо амжилтаа хэрэгжүүлэн ажиллаа. | |
| | 12.1.5 | **“Нутгийн соёл-Танаас эхлэнэ**” уриатайгаар “Соёлын давалгаа” үйл ажиллагааг зохион байгуулах | Зохион байгуулсан ажлын тоо | тоо | 1 | 2 | 100 0 | Жилдээ | Нутгийн соёл таниас эхлэн” уриатайгаар Соёлын давалгааг үйл ажиллагааны хүрээнд “Өв соёлын өлгий -Өндөршил” хөтөлбөрийг боловсруулах хэлэцүүлэг, Шилийн зоо, Их Бага баян уул, Жинст хайрхан, Улаан овоогоо тахьж, “Дурсамж тээсэн өв” аяныг 2 удаа өрнүүлэн ажилласнаар 38 иргэд нэгдэж өөрийн гар дээр үеэс үед өвлөгдсөн адуу, тэмээний өв соёлын эд зүйл, хэрэгсэлийг ахмадууд сэтгэл харамгүй хандивлаж Тэмээний өв соёлын танхим, “Адууны хийморь” булан танхим байгуулагдаж, “Малчдын зөвлөгөөнд” оролцогчдыг Морьтойгоо ирж оролцох уриалга гээд нийт 5 үйл ажиллагааг зохион байгуулж,Монгол ахуй соёлоо дээдэлсэн бусдад санаа сэдлийг өгсөн, талархал хүлээсэн, бүтээлч ажлууд зохиогдож, МОНЦАМЭ орон даяар сурталчлагдсан юм. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 12.1.6 | Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн “Соёлын солилцоо” туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулж, аялал жуулчлалыг хөгжүүлэн нутгийнхаа өв соёлыг сурталчилах. | Зохион байгуулсан ажлын тоо | Тоо | 1 | 5 | 3 сая | Иргэдийн хандив | ӨМӨЗО-ны Алтан гүүр аялал жуулчлалын ХХК Хүслэнгийн урилгаар Соёлын төвийн эрхлэгч нь Туршлага судлах хөтөлбөртэй аялалд хамрагдаж Өвөр монголчууд нь малын мах, сүү цагаан идээг уламжлалд тулгуурлан шинэ техник технологи нэвтрүүлж боловсруулдаг, сав баглаа боодол, нэр хаяг, шошго гээд л тухай боловсруулах бүтээгдхүүндээ зориулан хийж иргэдэдээ хүргэдэг гээд маш олон сайхан зүйлийг биетээр үзэж, байгууллагынхаа ажилтанууд болон ахмадуудад туршлагаа хуваалцлаа.Мөн тус ажлынхаа хүрээнд компаний захирал М.Хүслэн нь цас зудтай, хаваржилт хүндэрсэн цаг үед компаниар дамжуулан Өвөрмонголчуудын 36 133 юаний хандивыг иргүүлж,сумынхаа бүх малчин айл өрхүүдэд 10 литр бензин түгээж, хаваржилт хүндэрсэн малчин айлууд болон 20 өндөр настанд 1 шуудай нүүрс, 25 кг гурил, 5 кг цагаан будаа, 5-3 кг гоймон...зэрэг хүнсний тусламжийг хамт олноороо малчдад хүргэн ажиллаа.<br><br>Соёлын яамнаас зохион байгуулсан "Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл" өвийг | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | түгээн дэлгэрүүлэх, Монголын өв уламжлал, соёлын үнэт зүйлсийг сурталчлан таниулах, үр хойчдоо өвлүүлэх зорилготой "МОНГОЛ ГЭР" үзэсгэлэнд ОНС музейн 8 үзмэр, Нүүдэлчин монгол дэлхийн фестиваль наадамд 5 авьяастан, туршлага судлах ажиллагаанд -5 ажилтанаа хамрагдаж нутгийн өв соёлоо сурталчлан ажиллаа. | |
| Зорилго Дугуйлан сургалтын үйл ажиллагаа, сургалтын чанарыг сайжруулан, хөгжүүлэх, нэр төрлийг нэмэгдүүлэх. | | | | | | | | | | |
| Зорилт | 13.1 | Соёлын биет бус өвийн ажилтныг чадавхжуулах, өвлөн уламжлагчдыг дэмжих, шавь сургалтад суралцагчдын тоо 40 байсныг 120 болгон нэмэгдүүлнэ | Суралцагчийн тоо<br>өвлөн уламжлагчийн тоо<br>шавь сургалтын тоо | тоо | 54 | 74 | Улсын төсөв | Жилдээ | Тус үйл ажиллагааны хүрээнд 14 өвлөн уламжлагч нь язгуур урлаг, Уртын дуу, ардын хөгжим, Хонины ноосыг гар аргаар боловсруулах, самнах, эсгий гутал урлах, хурганы арьс элдэх энчлэх арга, товч шилбэ зангидах, зүймэл урлал зэрэг 7 төрлийн шавь сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 180 суралцагч хамрагдаж, суралцагчдынхаа эгнээг нэмэгдүүлж, өв соёлын боловсрол олгосон бүтээлч ажил боллоо. | 100% |
| Арга хэмжээ | 13.1.1 | Аймгийн театр болон МХО-ны ардын хөгжмийн багш нарыг орон нутагт урьж 7-14 хоногийг сургалтыг зохион байгуулах | Сургалтанд хамрагдсадын тоо | тоо | 0 | 2 | Улсын төсөв | Жилдээ | Аймгийн Цэнгээнт бүжгийн "Алтан өргөө бүжгийн холбоотой хамтарч<br>5 хоногийн сургалтанд 45 иргэд хамрагдаж цэнгээнт 16 бүжгийн анхан шатны мэдэгдхүүнтэй болж “Соёлын сэргэлт-2023” аян | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хүрээнд Аймгийн музей, Улсын хүүхэлдэйн театртай хамтран хүүхдүүдийн дунд шигтээ урлал, дүрслэх урлал, хүүхэлдэй урлал гэсэн 3 төрлийн сургалтанд 57 хүүхэд хамрагдаж, Хилийн цэргийн дуу бүжгийн чуулгын бүжигчин, багш Энх нар, Мөнхсайхан нарын 5 сургалтанд 78 сурагч хамрагдан шинээр 4 бүжиг сурч, авьяас ур чадвар, хөгжүүлэсэн урлагийн боловсролыг олгосон шинэлэг бүтээлч сургалтууд боллоо | |
| | 13.1.2 | Уртын дуу, морин хуураа дээдлэн дэлгэрүүлж судлах, хойч үедээ өвлүүлэх зорилгоор танхимын болон шавь сургалтыг зохион байгуулах. | Сургалтанд хамрагдагсадын тоо | тоо | 25 | 30 | Улсын төсөв | Жилдээ | Соёлын төвийн дэргэд уртын дууны сургагч багшаар Т.Мөнхцэцэг нь давхардсан тоогоор -223, Морин хуурын сургагч багш Ч.Мөнхбаяр нь давхардсан тоогоор 75 сурагч,танхимаар нийт 298 сурагчийг хамруулан хичээллэж, эгнээг өргөжүүлэн, урын санг баяжуулан,дуулах, хөгжимдөх ур чадварыг хөгжүүлж, залуу хойч үедээ уртын дуу, морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх өвлүүлж уламжлуулах үйлсэд идэвхи санаачлагатай ажиллаа. | 100% |
| | 13.1.3 | Өвлөн уламжлагчдын шавь сургалтын эгнээг өргөжүүлэх. | Шинээр төрсөн шавь нарын тоо | тоо | 100 | 306 | Улсын төсөв | Жилдээ | Өвлөн уламжлагчдын шавь сургалт нь эсгий урлал, товч шилбэ зангидах, хулсан хуур тоглох, уртын дуу сурах, арьс элдэх энчлэх, Хүнсний нарийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сургалт хийсэн тоо | | | | | | ногоо тариалах, дээс томнох, утас ээрэх гээд сургалтууд нь урьд оныхоос 9-ээр нэмэгдэж суралцагчдын тоо 180 болж, 60 суралцагч нэмэгдэж эгнээ нь өргөжиж, сургагч багшаар 14 өвлөн уламжлагч ажиллаа. Тус шавь сургалтын үр дүнгээр уламжлалт нүүдлийн мал аж ахуйн өв соёлоос суралцаж, өвлүүлж уламжлуулсан,сургагч багш нарынхаа ажлыг үнэлж Аймгийн гэрийн сайн багш цол тэмдгээр 9 өвлөн уламжлагч шагнуулж, ач холбогдолоо өгсөн сургалт боллоо. | |
| | 13.1.4 | ”Өсвөрийн номын санч“, “Соёлын өв хамгаалагч “клубүүд байгуулах | Суралцагчийн тоо | Тоо | 16 | 16 | ОНТ | Жилдээ | Номын сангийн Оюунлаг тархи номын клуб, ОНС музейн Соёлын өв хамгаалагч гэсэн 2 клуб байгуулагдлаа. Тус клубт нийт 27 хүүхэд хамрагдаж чөлөөт цагаар ном уншиж, уншсан номын ярилцлага зохиох,уншсан номынхо тэмдэглэлийг хөтлөх, түүх өв соёл, ёс заншилтайгаа танилцах, Ном унших дадлаар дамжуулан суралцахуйн үйл ажиллагааг дэмжсэн мэдлэг оюунаа тэлсэн бүтээлч үйл ажиллагууд зохиогдов. | 100% |
| | 13.1.5 | “Соёлын өв-Бидний бахархал” нэрэмжит аймаг, сум, бүсийн үйл | Сумын шилдэг авьяастануу | тоо | 0 | 2 | Улсын төсөв | Жилдээ | ӨВ СОЁЛ -БИДНИЙ БАХАРХАЛ-2022” Аймгийн урлагийн бага наадмыг орон нутагтаа зохион байгуулж 8 сумын 66 авьяастанууд, 8 төрөл дээр үр | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагаа зохион байгуулах. | д тодорсон байх<br>Авьяастаны тоо | | | | Иргэдийн хандив | | чадвараа сорин наадаж нийт 17 авьяастан шагнагдаж “Шилдэгийн шилдэг” авьяастанаар Цагаандэлгэр сумын Э.Дорждавга нь Гранпри шагналыг хүртсэн юм. Тэмээний соёл- Тэмээчдийн баяр-2022, 2023 баяраар бүсийн Ерөөл магтаалчдын болон ”Тэмээний тухай дууг хэн сайн дуулах уралдаануудад нийт 21 авьяастан ур чадвараа сорьж, МУ-ын аварга малчин агсан Т.Лувсанбалдангийн үр хүүхдүүд ивээн тэтгэлээ. Тус үйл ажиллагаанууд нь өргөн цар хүрээтэйгээр зохион байгуулагдаж,Соёлын биет бус өвөө хадгалж хамгаалсан, мартагдсан өв соёлоо сэргээсэн,Шилдэг өвлөн уламжлагч нараа тодоруулж алдаршуулсан нутгийн өв соёл, онцлох ажлаараа тус тус МОНЦАМЭ Улс, аймгийн хэмжээнд сурталчлагдсан юм. | 100% |
| Зорилго:Хүн амын боловсрол, соёл мэдээлэл, соёл чөлөөт цагийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн номын сан, ном зүйн үйлчилгээг үзүүлж, Хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх, зерэг хандлага, дадлыг бий болгон, бие хүнийг бүтээлчээр хөгжүүлэхэд оршино. | | | | | | | | | | |
| Зорилт | 14.1 | Номын сангийн байнгын уншигч 536 байсныг 2024 онд 877, олговол зохих номын тоо 2020 онд 870 байсныг 2024 онд | Ном уншигчийн тоог нэмэгдүүлэх | Тоо | 86 | 344 | ОНТ | Жилдээ | Номын сангийн байнгын уншигч 903 хүргэж 26 уншигчаар нэмэгдүүлж, олговол зохих номын тоо 3578 хүрч, шинэ уншигч 369 хүрч, шинэ уншигчийн тоог 25 уншигчаар нэмэгдүүлэн ажиллаж | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3480, шинэ уншигч 2020 онд 86 байсныг 2024 онд 344 болгон нэмэгдүүлнэ. | | | | | | | бодлогын зорилтоо амжилттай хэрэгжүүлсэн байна. | |
| Арга хэмжээ | 14.1.1 | Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргах | Гаргасан үзэсгэлэнгийн тоо | тоо | 15 | 17 | ОНТ | Жилдээ | Номын сан нь шинэ номын үзэсгэлэн 6 удаа, Төрт ёс хаадын сан, Бүсгүй, Номтой нөхөрлөе, Бидний бахархал эр цэрэг, Эрүүл мэнд эрхэм баян,гэр бүлийн багц, “Эх хэл бидний бахархал, Миний монгол бичиг минү гээд сэдэвчилсэн 72, нийт 78 удаа үзэсгэлэн гаргаж, 1813 ном уншигч олонд сурталчлагдаж давхардсан тоогоор 1264 уншигч үзсэн байна. | 100% |
| | 14.1.2 | Номын баяр, уншигчдын бага хурал, уулзалт арга хэмжээг зохион байгуулах“Олуулаа ном уншицгаая” Иргэдийг номтой нөхөрлүүлэх аян зохион байгуулах. | арга хэмжээ зохион байгуулсан байх | тоо | 5 | 5 | 100 000 | Жилдээ | Номын сан нь жил бүр номын баяраа тэмдэглэж “Номын өргөөний ид шид” сэдвээр уншигчдын 3 үеийн уулзалт, Баярлалаа хайртай шүү дүү шүлгийн уралдаан, Үлгэрээс үлгэрлэе”,“Номтой нөхөрлөе”-сарын аян,Уншаад ургашлахуй”ном уншлага, “Миний монгол бичиг -2023 сайхан бичигтэн” уралдаан, Түргэн хэллэг, Алтан хонх,Ном хож танин мэдэхүйн тэмцээн .Уран жиргээ-2024 уран уншлагын уралдаан, "Миний нутгийн бахархал"гар зургийн уралдаан | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | гээд нийт 28 үйл ажиллагаа зохион байгуулж,давхардсан тоогоор 578 уншигчдад үйлчилж номтой нөхөрлөх, ном унших соёлд сургах,хүн бүрийн номтой ойр байхыг уриалсан бүтээлч ажлууд зохиогдлоо. | |
| | 14.1.3 | Номын сангийн фонд бүрдүүлэлтийг сайжруулах, жил бүр шинэ номоор баяжуулах**.** | фонд баяжилтын номын тоо | тоо | 70 | 80 | Байгууллага төсөв хандив | Жилдээ | 2021-2024 онд номын сангийн цонд бүрдүүлэлт нь Улсын төсвөөс 1742,300 төгрөгөөр 115 ш ном, Уншигчдынхаа дунд жил "Нэг ном -нэг хүүхэд" 14-21 хоногийн аян,нэг ном-нэг иргэн зэрэг хандив өрнүүлэн ажилласны үр дүнд 2772,050 төгрөгнд 165 ном тус тус цуглуулсан байна. Нийт 4514,350 төгрөгний 280 ш номтой болж журмын дагуу бүртгэлд оруулж, номын сангийхаа фондыг бүрдүүлж уншигч олны хүртээл болгох ажилласан байна. | 100% |
| | 14.1.4 | Мөрөөдлийн самбараа хамтдаа бүтээцгээе, болон ширээний театр уралдааныг тус тус зохион байгуулах. Гэрээр "Номын богц" аялуулж, эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамтран ном унших дадлыг хэвшүүлэх. | гэр бүлээр ном уншигчийн тоо | тоо | 2 | 2 | Улсын төсөв хандив | Жилдээ | Соёлын төв нь "Мөрөөдлийн самбараа хамтдаа бүтээцгээе "Ширээний театр урлан бүтээх уралдааныг СӨБ-ын Ахлах, Бэлтгэл бүлэг,ЕБС -ийн 1-5 ангийн дунд зохион байгуулахад хүүхдүүд нь гарын доорхи материалыг ашиглан өөрийн уншсан номынхоо Гурван тоорой үлгэр, Манжин, Ноён талхын үсчний газар, Ойн амьтад, Долоон өндөгтэй доголон | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | шаазгай, Эвтэй дөрвөн амьтан гэх мэт 15 үлгэрийн баатрыг урлан хийсэн нь хүүхдүүдийн сэтгэлгээг хөгжүүлсэн бүтээлч ажил боллоо.<br><br>Гэр бүлээрээ ном уншигчдын ном унших идэвхи санаачлагыг өрнүүлэх зорилгоор Дундговь аймгийн Төв номын сантай хамтран ном солилцооны гэрээг 2 удаа байгуулж, уншигч гэр бүлийн дунд "Нүүдлийн номын үйлчилгээг 6, удаа,"Шидэт номын богц" үйлчилгээг 4, нийт 10 үйлчилгээг зохион байгуулж давхардсан тоогоор 20 гэр бүл 185 ном уншиж мэдлэг оюунаа хөгжүүлж хүүхдүүдэдээ ном унших дадлыг хэвшүүлэхэд үүрэг гүйцэтгэн ажиллаа. | 100% |
| | 14.1.5 | Танд ойрхон номын сан" зуныг номтой өнгөрүүлэх аяныг зохион байгуулах. | аян өрнүүлэн ажилласан байх | тоо | 0 | 1 | Улсын төсөв хандив | Жилдээ | Танд ойрхон номын сан аян, ИТХ-ын нутгийн удирдлага, нийгмийн хөгжлийн хороотой хамтран сургуулийн сурагчдын дунд зуны амралтаар нь" Номтой нөхөрлье" аяны хүрээнд 36 сурагч уншсан номын тэмдэглэл бүтээлийн үзэсгэлэн гаргалаа. Шилдэг уншигч Энхрийлэн уншсан номынхоо тэмдэглэгээ өөрийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | туршлагаасаа хуваалцав.Аяныг 2 удаа зохион байгуулж Ч.Цэрэнпүрэв багштай 7а, Алтан зул багштай 9-р ангийн хамт олон манлайлж,тэргүүний уншигч 16 уншигчдыг тодоруулан алдаршуулав. Тус аяны хүрээнд давхардсан тоогоор 254 уншигч үзсэн байна. | |
| | 14.1.6 | Уншигчдын дунд "Тойрон аялал үлгэрийн баатрууд танай ангиар зочлох нь" аяныг зохион байгуулах. | Аян зохион байгуулсан тоо<br>Хамрагдсан хүний тоо | Тоо<br>Тоо | 1<br>20 | 2<br>50 | ОНТ | Жилдээ | Номын сангийн Оюунлаг тархи номын клуб нь Үлгэрийн орноор аяласан нь” гар зургийн уралдаан,“Үлгэрийн баатар танай ангиар зочилсон нь" аяныг 6 удаа зохион байгуулж Орос ардын “Өнхрүүш”үлгэр,МА үлгэр 7 хожгор, нэг можгор, эрхий мэргэн,7 өндөгтэй доголон шаазгай,Ухаант туулай үлгэрийн дүр тоглолтуудыг хийж, баримлын шавраар урлаж бүтээх, үлгэрийн баатруудыг цэцэрлэг, сургуулийн бага ангиудаар аялуулан таниулан сурталчилж,Монголын хүүхэдэйн кино “Мөнх тунх” киног нүүдлийн үйлчилгээгээр Цэцэрлэгийн 4 бүлгийн нийт 65 баяцхан үзэгчдэд хүргэж хүүхдүүдийг номтой нөхөрлүүлж, ном унших идэвхи сонирхолыг өрнүүлж үйл ажиллагаанд давхардсан | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | тоогоор 136 бяцхан уншигч, сонирхогчид хамрагдсан байна. Соёлын сэргэлт-2023” аяны үйл ажиллагааны хүрээнд Монгол улсын хүүхэлдэйн театрын шинэ уран бүтээл О.Сундуйн зохиол “Хүүхэлдэйн чинээ ээж” хүүхэлдэйн жүжгийг тоглолт үзэгч олондоо хүргэн ажиллаа. | |
| Зорилго:Сумын нутаг дэвсгэрт байгаа соёлын биет болон биет бус өвийг олж илрүүлэх, судлах, бүртгэн баримтжуулах, хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлэх. | | | | | | | | | | |
| Зорилт | 15.1 | Уламжлалт өв соёлоос суралцах, өвлүүлэн үлдээх, хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | Зохион байгуулсан ажлын тоо | тоо | 8 | 15 | ОНТ | Жилдээ | Тэмээний соёл-Тэмээчдын баярын үйл ажиллагааны хүрээнд Шилмэл ингэ, буур шалгаруулах,Сайхан тэмээтэй хос, Бүсийн ерөөл магтаалчдын,Тэмээний тухай дууг хэн сайн дуулах вэ, Тэмээ тэнгэрлэг амьтан гар зургийн уралдаан, угсаатны зүйн гар урлалын үзэсгэлэн, тэмээний өв соёл, түүхээ сурталчлсан цахим мэдээлэл -15, Улс аймгийн аварга тэмээчдын ажил үйлс амжилт бүтээл болон шилмэл ингэ буураа сурталчлсан цахим контент -5 гээд 4 төрлийн 15 үйл ажиллагаа, Уячид дуулж байна-2024 уралдаан, Үндэсний бичиг үсгийн баяр, Угийн бичигтэн удамынхан ургийн баяр, Алтан хэлхээ 3 үеийн уулзалт гээд 34 буюу нийт | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 49 үйл ажиллагаа зохион байгуулан ажиллав.Орон нутаг судлах музейдээ Адууны хийморь, Тэмээний өв соёлын булан танхимыг тус тус байгуулж нутгийн бахархал адуу,тэмээний өв соёлоос хүүхэд залуучууд суралцах, таниулах, өвлүүлж, уламжлуулах, хөгжүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлсэн бүтээлч ажлууд хийгдснээр онцлох болж Богдын төмөр тэмээн сургийн үржил тамга Өндөршил суманд бий, Тэмээний өв соёлын танхимтай боллоо гэсэн гарчигтайгаар МОНЦАМЭ -олон нийтэд сурталчлагдлаа. | |
